



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар A/07

Хархорин сум

Г Эзэмшил газрын зориулалт өөрчлөх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Эрдэнэзуу гудамж 1-116 тоотод иргэн Т.Тогтохбаярын худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар эзэмшиж байгаа 6209002493 нэгж талбарын дугаартай 1713м<sup>2</sup> газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон өөрчилсүгэй.

2. Газар эзэмшигч Т.Тогтохбаярт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Т.Тогтохбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ

